

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/13/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: Б.Мөнхбамбар
Утас: 70512127 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Төлбөрийн акт.....	15
4.2 Албан шаардлага	15
4.3 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Холбоо. А.Б. Д.Б. № 30

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Д.МӨНХЗУЛ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	703,347,278.41	2,775,091,854.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	6,312,582.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	6,312,582.61
3121	Төгрөг	00.00	6,312,582.61
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,263,001.15
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	5,049,581.46
33	АВЛАГА	37,621,650.53	2,107,408,022.80
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	2,104,253,684.80
335	Бусад авлага	37,621,650.53	3,154,338.00
3351	Байгууллагаас авах авлага	37,621,650.53	3,154,338.00
35	БАРАА МАТЕРИАЛ	665,725,627.88	661,371,249.55
351	Түүхий эд материал	320,791,441.13	268,040,966.07
35130	Эм боох материал	320,791,441.13	268,040,966.07
354	Хангамжийн материал	344,934,186.75	393,330,283.48
35410	Бичиг хэргийн материал	4,737,680.00	2,485,160.00
35420	Аж ахуйн материал	5,695,214.50	5,003,158.65
35440	Түлш, шатах тослох материал	8,645,191.00	9,775,750.20
35460	Хүнсний материал	13,803,566.44	11,234,283.51
35470	Бусад хангамжийн материал	312,052,534.81	364,831,931.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,255,670,208.51	11,442,540,187.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,255,670,208.51	11,442,540,187.55
392	Биет хөрөнгө	9,801,386,208.51	10,988,256,187.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,197,023,101.00	7,197,023,101.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-324,205,248.35	-506,683,632.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	559,271,058.00	598,771,058.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-358,901,272.44	-428,080,576.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,440,081,131.40	8,846,025,161.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,847,151,970.45	-4,864,346,960.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	472,262,280.00	525,092,530.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-342,594,570.57	-384,833,692.36
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,500,000.00	2,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-625,000.08	-937,500.12
39217	Ном	726,700.00	726,700.00
393	Биет бус хөрөнгө	454,284,000.00	454,284,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	454,284,000.00	454,284,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,959,017,486.92	14,217,632,042.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,015,872,950.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,015,872,950.56
413	Өглөг	00.00	1,015,872,950.56
4136	Бусад өглөг	00.00	1,015,872,950.56
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	1,015,433,665.37
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	439,285.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,959,017,486.92	13,201,759,091.95
51	Засгийн газрын хувь оролцоо	10,959,017,486.92	13,201,759,091.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,682,328,865.24	3,682,328,865.24
51101	Өмч: - төрийн	3,682,328,865.24	3,682,328,865.24
512	Хуримтлагдсан үр дүн	3,917,406,873.56	6,160,148,478.59
51210	Өмнөх үеийн үр дүн	3,917,406,873.56	3,893,384,198.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,266,764,280.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,359,281,748.12	3,359,281,748.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,959,017,486.92	14,217,632,042.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,366,778,448.12	14,808,890,133.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,793,620,892.12	3,615,992,180.41
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	232,891,203.34	1,155,678,000.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,036,191.00	118,096,654.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,735,147.95	2,265,420.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	105,119,864.39	1,035,315,926.71
122	Тусламжийн орлого	2,560,729,688.78	2,460,314,179.70
122001	Хандив тусламж /дотоод/	1,919,566,052.42	2,460,314,179.70
122002	Хандив тусламж /гадаад/	641,163,636.36	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,573,157,556.00	11,192,897,953.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,398,030,700.00	1,339,973,220.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,398,030,700.00	1,339,973,220.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,803,373.00	1,041,797,877.46
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	34,346,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,158,446.00	788,086,157.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,644,927.00	219,365,720.46
1330	Төсвийн захирагчдаас	00.00	500,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	350,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	150,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,053,323,483.00	8,311,126,856.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,053,323,483.00	8,311,126,856.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,488,367,240.01	12,542,125,853.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,488,367,240.01	12,542,125,853.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,468,274,018.80	12,073,111,577.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,307,655,129.62	4,956,806,782.80
210101	Үндсэн цалин	2,555,058,417.23	2,965,926,675.09
210102	Нэмэгдэл	1,136,767,312.02	1,409,646,736.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	214,785,349.39	195,727,410.32
210104	Урамшуулал	401,044,050.98	385,505,960.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	587,447,805.95	697,518,500.00
210201	Тэтгэврийн даатгал	412,595,630.45	518,994,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	43,754,899.76	44,631,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,003,899.82	35,704,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,750,999.89	8,926,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	87,342,376.03	89,262,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	767,903,846.95	818,723,928.70
210301	Гэрэл, пахилгаан	92,868,596.95	104,496,488.00
210302	Түлш, халаалт	591,373,150.00	591,177,220.70
210303	Цэвэр, бохир ус	83,662,100.00	123,050,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	150,192,930.59	222,861,913.62
210401	Бичиг хэрэг	10,467,047.73	13,799,393.82
210402	Тээвэр, шатахуун	80,683,590.00	125,316,520.80
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	5,032,746.16	1,199,570.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	47,651,989.70	81,894,629.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,357,557.00	651,800.00
2105	Нормативт зардал	1,517,573,365.04	3,932,065,744.58
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,321,558,531.66	3,573,110,638.15
210502	Хоол, хүнс	185,999,533.38	358,145,106.43
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,015,300.00	810,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,788,644.60	68,819,292.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,296,600.00	00.00
210602	Тавилга	1,022,200.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	495,000.00	00.00
210604	Урсгал засвар	59,974,844.60	68,819,292.00
2107	Томилголт, зочны зардал	15,861,000.00	5,854,000.00
210702	Дотоод албан томилголт	15,861,000.00	5,854,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,991,738.00	58,568,514.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,120,500.00	37,212,760.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,170,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,763,340.00	1,912,425.00

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	242,864.00	367,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	276,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,065,200.00	9,296,281.95
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,068,130.00	8,273,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,019,859,558.05	1,311,892,900.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,439,946.00	488,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,018,419,612.05	1,311,404,300.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,093,221.21	469,014,276.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,002,000.00	469,014,276.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,002,000.00	469,014,276.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,091,221.21	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,091,221.21	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,878,411,208.11	2,266,764,280.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	74,289,750.04	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	74,289,750.04	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-74,289,750.04	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,804,121,458.07	2,266,764,280.56

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,228,044,865.24	1,809,420,143.27	3,327,372,708.22	00.00	8,364,837,716.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,228,044,865.24	1,809,420,143.27	3,327,372,708.22	00.00	8,364,837,716.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-356,452,562.36	00.00	-356,452,562.36
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	3,917,406,873.56	00.00	10,959,017,486.92
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	3,917,406,873.56	00.00	10,959,017,486.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-24,022,675.53	00.00	-24,022,675.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	3,893,384,198.03	00.00	10,934,994,811.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,266,764,280.56	00.00	2,266,764,280.56
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,682,328,865.24	3,359,281,748.12	6,160,148,478.59	00.00	13,201,759,091.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,691,412,747.00	9,220,655,559.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,255,191.00	118,166,654.00
120	Нийтлэг татварын бус орлого	118,255,191.00	118,166,654.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,255,191.00	118,166,654.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,036,191.00	118,096,654.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,219,000.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	7,573,157,556.00	9,102,488,905.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,398,030,700.00	1,339,973,220.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,398,030,700.00	1,339,973,220.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,803,373.00	1,034,034,514.46
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	34,346,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,158,446.00	776,922,794.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,644,927.00	222,765,720.46
1330	Төсвийн захирагчдаас	00.00	500,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	350,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	150,000,000.00

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,053,323,483.00	6,228,481,171.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,053,323,483.00	6,228,481,171.20
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,619,669,067.00	9,176,382,877.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,619,669,067.00	9,176,382,877.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,589,131,208.79	8,701,368,601.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,324,716,839.83	4,955,680,397.61
210101	Үндсэн цалин	2,571,961,133.03	2,964,800,289.90
210102	Нэмэгдэл	1,136,926,306.43	1,409,646,736.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	214,785,349.39	195,727,410.32
210104	Урамшуулал	401,044,050.98	385,505,960.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	587,447,805.95	697,518,500.00
210201	Тэтгэврийн даатгал	412,595,630.45	518,994,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	43,754,899.76	44,631,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,003,899.82	35,704,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,750,999.89	8,926,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	87,342,376.03	89,262,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	762,908,956.95	616,559,178.00
210301	Гэрэл, цахилгаан	87,873,706.95	102,265,738.00
210302	Түлш, халаалт	591,373,150.00	434,104,280.00
210303	Цэвэр, бохир ус	83,662,100.00	80,189,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	158,553,837.89	217,258,905.07
210401	Бичиг хэрэг	14,612,160.73	14,186,339.82
210402	Тээвэр, шатахуун	86,316,400.00	125,970,830.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	3,415,870.16	2,017,875.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	42,009,840.00	57,624,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,199,567.00	17,459,380.00
2105	Нормативт зардал	1,632,353,622.17	2,082,081,830.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,428,224,313.07	1,767,759,975.17
210502	Хоол, хүнс	175,061,659.10	307,690,355.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,067,650.00	6,631,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,538,716.00	72,651,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,563,400.00	17,947,100.00
210602	Тавилга	1,362,100.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	495,000.00	00.00
210604	Урсгал засвар	55,118,216.00	54,704,500.00
2107	Томиллолт, зочны зардал	15,861,000.00	5,854,000.00
210702	Дотоод албан томиллолт	15,861,000.00	5,854,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,310,484.00	53,275,589.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,645,500.00	37,212,760.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,170,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,763,340.00	1,912,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	242,864.00	367,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	276,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,556,576.00	8,975,076.70
210807	Газрын төлбөр	1,285,704.00	1,285,704.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,370,500.00	3,302,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,439,946.00	488,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,439,946.00	488,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,537,858.21	475,014,276.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,002,000.00	475,014,276.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,002,000.00	475,014,276.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,535,858.21	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,535,858.21	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	71,743,680.00	44,272,682.61
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	71,743,680.00	37,960,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,743,680.00	37,960,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	71,743,680.00	37,960,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	71,743,680.00	37,960,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-71,743,680.00	-37,960,100.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	6,312,582.61
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	6,312,582.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,718,648,600.00	8,185,358,044.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,718,648,600.00	8,185,358,044.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,712,728,600.00	8,179,942,794.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,463,099,700.00	4,616,547,796.61
210101	Үндсэн цалин	2,657,502,600.00	2,625,667,688.90
210102	Нэмэгдэл	1,191,448,700.00	1,409,646,736.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	215,523,000.00	195,727,410.32
210104	Урамшуулал	398,625,400.00	385,505,960.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	602,518,500.00	697,518,500.00
210201	Тэтгэврийн даатгал	423,994,500.00	518,994,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	44,631,000.00	44,631,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,704,800.00	35,704,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,926,200.00	8,926,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	89,262,000.00	89,262,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	912,858,200.00	616,559,178.00
210301	Гэрэл, цахилгаан	89,706,700.00	102,265,738.00
210302	Түлш, халаалт	703,771,200.00	434,104,280.00
210303	Цэвэр, бохир ус	119,380,300.00	80,189,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	153,595,200.00	220,248,905.07
210401	Бичиг хэрэг	7,924,800.00	14,186,339.82
210402	Тээвэр, шатахуун	92,332,800.00	125,970,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,961,600.00	2,017,875.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	39,880,800.00	57,624,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	10,495,200.00	20,449,380.00
2105	Нормативт зардал	1,457,875,500.00	1,928,500,984.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,234,513,100.00	1,614,179,129.17
210502	Хоол, хүнс	190,220,000.00	307,690,355.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,142,400.00	6,631,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,028,300.00	70,535,600.00
210601	Багаж, техник хэрэгсэл	20,733,400.00	12,077,100.00
210602	Тавилга	00.00	2,286,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,063,900.00	00.00
210604	Урсгал засвар	32,231,000.00	56,172,500.00
2107	Томилголт, зочны зардал	25,893,100.00	5,052,000.00
210702	Дотоод албан томилголт	25,893,100.00	5,052,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,860,100.00	24,491,229.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,600,000.00	8,428,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,170,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,770,000.00	1,912,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,122,000.00	367,624.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,100,000.00	8,975,076.70
210807	Газрын төлбөр	804,000.00	1,285,704.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,894,100.00	3,302,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	488,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	488,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	592,000.00	541,525.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,920,000.00	5,415,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,920,000.00	5,415,250.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,718,648,600.00	8,186,621,045.20
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,377,077,100.00	1,339,973,220.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,377,077,100.00	1,339,973,220.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,220,298,200.00	6,728,481,171.20
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	350,000,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,220,298,200.00	6,228,481,171.20
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	150,000,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	121,273,300.00	118,166,654.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	121,273,300.00	118,096,654.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	70,000.00
5	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,263,001.15
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	340.00	340.00
620001	Удирдах ажилтан	04.00	04.00
620002	Гүйцэтгэх ажилтан	261.00	261.00
620003	Үйлчлэх ажилтан	75.00	75.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,028,984,933.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,028,984,933.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		559,385,907.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		339,132,601.00
210101	Үндсэн цалин		339,132,601.00
2105	Нормативт зардал		153,580,846.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		153,580,846.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		37,086,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		27,079,000.00
210602	Тавилга		10,007,100.00
2107	Томилолт, зочны зардал		802,000.00
210702	Дотоод албан томилолт		802,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		28,784,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		28,784,360.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	469,599,026.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		469,599,026.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		469,599,026.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1034034514.46
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,034,034,514.46
131103	ЗГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		34,346,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		776,922,794.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		222,765,720.46
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,049,581.46

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, тээвэр шатахуун, үндсэн хөрөнгө, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг нь “Эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай үзүүлнэ.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 8,510.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 85.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 59.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,258.6 сая төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	6.30	6.30
Авлага	37.60	2,107.40	2,069.80
Бараа материал	665.70	661.40	(4.30)
Үндсэн хөрөнгө	10,255.70	11,442.50	1,186.80
Нийт хөрөнгө	10,959.00	14,217.60	3,258.60
Өр төлбөр	0.00	1,015.90	1,015.90
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,959.00	13,201.70	2,242.70
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,959.00	14,217.60	3,258.60

Авлага дансны үлдэгдэл 2,107.4 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас 11, 12 дугаар сарын санхүүжилт олгогдоогүй нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,217.6 сая төгрөг болж 1,186.8 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс Эрүүл мэндийн яам болон бусад байгууллагаас 2,460.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь өсөхөд гол нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,015.9 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас 11, 12 сарын санхүүжилт олгоогүйтэй холбоотой үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,201.7 сая төгрөг болж 2,242.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 14,808.9 сая төгрөгөөр буюу 43 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,470.9 сая төгрөгөөр буюу 73 хувиар өсөж, тайлант үед 3,495.6 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 5,257.8 сая төгрөгөөр буюу 272 хувиар өсөж, тайлант онд 8,311.1 сая төгрөг болж нэмэгдсэн нь үр дүнгийн тайлангийн орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 4,053.7 сая төгрөг буюу 47 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, элэгдэл зэрэг зардлууд байна. Энэ нь ковид19 цар тахлын үед ажилласан албан хаагчдын илүү цагаар ажилласан ажлын хөлс, хэвтэн эмчлүүлсэн иргэдийн эм, эмнэлгийн хэрэгслийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,570.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 7,570.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжих болсон бөгөөд тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,718.6 сая төгрөгийн төсөв баталснаас 4,377.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 121.2 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 3,220.3 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,340.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 350.0 сая төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагчаас, 150.0 сая төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт, 6,228.5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 118.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 8,185.4 сая төгрөгийг зарцуулж, 1.2 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,185.4 сая төгрөг буюу 106 хувьтай байгаа нь төсвийн ерөнхийлөн захирагчаас 500.0 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй санхүүжилт олгосонтой холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 776.9 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 222.8 сая, ЗГНХ,ЗДНХ,Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 34.3 сая нийт 1,034.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 339.1 сая, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 153.6 сая, эд хогшил, урсгал засварын зардал 37.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 28.8 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 469.6 сая, дотоод албан томилолт 0.8 сая, нийт 1,029.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 5.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайланд эрүүл мэндийн даатгалын сангаас 2,104.3 сая төгрөгийн авлагатай, иргэн, хуулийн этгээдэд 1,015.8 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй байна. Уг авлагыг 2022 оны 01 сард бүрэн олгосон бөгөөд 2021 оны төсвийн үлдэгдэл 1,088.5 сая төгрөг байна. Төсвийн үлдэгдлийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг баримтлан, дээд шатны төсвийн захирагч болон төсөв батлах эрх бүхий байгууллагын шийдвэрээр зарцуулах эрх олгох эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа хоцорч 7 мэдээлэл, мэдээлээгүй 3 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 55.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1 зөвлөмж, зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	27.4	2	27.4	-	-	-
Албан шаардлага	2	28.0	2	28.0	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	-	-	-
Нийт дүн	3	55.4	3	55.4	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4 асуудалд зөвлөмж өгсөн.

4.1 ТӨЛБӨРИЙН АКТ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/69 дүгээр тушаалд зааснаас бусад албан тушаалтанд 12.4 сая төгрөгийн хариуцлагын нэмэгдлийг бодож олгон төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 /Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй./, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/69 дүгээр тушаалын 1.9 /Эрүүл мэндийн салбар нь хариуцлагатай албан тушаал болох тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-аас доошгүй хувиар, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээтэй эд хариуцагч нарт үндсэн цалингийн 8-аас доошгүй хувийн нэмэгдэл хөлс олгох./ дэх заалтын тус тус зөрчсөн байна

4.2 АЛБАН ШААРДЛАГА

Аймгийн нэгдсэн эмнэлгийн даргаар ажиллаж байсан Д.Мөнхзулыг ажлаас үндэслэлгүй халсан болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 /Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй./, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 /Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ./, 103.2 /Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна./ дахь заалтыг зөрчсөн байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 789 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах мэдээллээс 7 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах

4. Тээвэр шатахуун зардалтай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Бензин шатахууныг замын тооцооны хуудсаар бодохдоо Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалыг баримтлаагүй бөгөөд батлагдсан нормын дагуу олгоогүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Шатахууныг олгохдоо Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан норм нормативыг мөрдөж ажиллах

5. Авлагатай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2,104.3 сая төгрөгийн авлагатай, иргэн, хуулийн этгээдэд 1,015.8 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй байна. 2022 оны 01 дүгээр сард авлага бүрэн төлөгдсөн бөгөөд 1,088.5 сая төгрөгийн төсвийн үлдэгдэлтэй байна. Уг төсвийн үлдэгдлийг Төсвийн тухай хуульд заасны дагуу дээд шатны төсөв захирагч болон төсөв батлах эрх байгууллагын шийдвэрээр зарцуулагдахаар байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Дээд шатны төсөв захирагч болон төсөвт батлах эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа Төсвийн үлдэгдлийг зарцуулахыг зөвлөмж болгож байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	7	24.5	-	-	1	12.5	1	12.0	5	-